

**Зүрх судасны төвийн эрдмийн чуулган, Зүрх судасны үндэсний
конференцид хэвлүүлэх
бүтээлийг бичих журам**

Зүрх судасны төвийн эрдмийн чуулган, Зүрх судасны үндэсний конференцид материал ирүүлэхдээ энэхүү зааврыг мөрдөнө. Үүнд:

1. Бүтээлийг А4 хуудасны нэг талд 31 мөрөөр Arial шрифтээр, 12-ын үсгээр, мөр хоорондын зай “Single” байна.
2. Бүтээл нь хүснэгт, зураг, ном зүй, товчлолыг оролцуулан 10 хуудаснаас хэтрэхгүй хэмжээтэй байна.
3. Эхэнд нь бүтээлийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн харъяалагдах албан байгууллагын нэр, гол судлаачдын и-мэйл хаягийг бичнэ. Жишээ нь:

**ГОЛ СУДАСНЫ НУМЫН САЛААНЫ ЭМГЭГИЙН
МЭС ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛД**

Д.Цэгээнжав, Д.Бат-Ундрал, Ж.Эрдэнэсүрэн, Ч.Золжаргал
П.Н.Шастины улсын III төв эмнэлэг

Хэрэв зохиогчид өөр өөр байгууллагад ажилладаг бол:
Д.Цэгээнжав¹, Д.Бат-Ундрал², Ж.Эрдэнэсүрэн¹, Ч.Золжаргал³
¹П.Н.Шастины улсын III төв эмнэлэг
²Анагаах ухааны хүрээлэн
³Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

4. Бүтээл нь оршил, материал, арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.
5. Бүтээлийг сайтар нягталсан, математик, химийн томъёог шалгасан, алдаа мадаггүй байна.
6. Зурагласан материалын тоо цөөн, фото зураг тод байна. Зургийн нэрийг зургийн дор бичнэ.
7. Хүснэгт нь сайн шахах хийсэн, хүснэгтийн бүх тоон утга нь бүтээлийн агуулгатай бүрэн тохирсон, хүснэгтийн нэр товч, оновчтой байна.
8. Ном зүйн жагсаалтыг тусгай хуудсан дээр, ишлэл авсан дарааллын дагуу бичнэ. Ном зүйн жагсаалтад зохиогчийн нэр, бүтээлийн нэр, хэвлэлийн нэр, хэвлэсэн газар, он, дугаар, хуудсыг заавал бичнэ. Жишээ нь:
Murray CJ, Lopez AD. Mortality by cause for eight regions of the world: Global Burden of Disease Study. Lancet 1997;349:1269-1276.

Зохиогч нар илтгэлийн хураангуйн найруулга зүй, үг үсгийн алдааг хариуцах учир хянуур нямбай хандахыг хүсье.

Бүтээлийг доох хаягаар илгээнэ үү.
conference@telemedicine.mn